МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА
Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026·09·03 № 53

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
НЯМ-ОСОРЫН УЧРАЛ ТАНАА

Төсвийн хууль тогтоомжийн
хэрэгжилтийн талаар

2024 оны 11 дүгээр сард Монгол Улсын Ерөнхийлөгч 2025 оны төсвийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид бүхэлд нь хориг тавихдаа Монгол Улсын эдийн засаг, төсөв гадаад зах зээл, уул уурхайн бүтээгдэхүүний үнэ, экспортын орлогоос өндөр хамааралтайг харгалзан эдийн засгийн таатай үед төсвийн хуримтлалыг нэмэгдүүлэх, өрийн дарамтыг бууруулах, мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлэх, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, алдагдалгүй төлөвлөх шаардлагыг тавьсан.

Монгол Улсын Их Хурал уг хоригийг хүлээн авсны дараа Засгийн газар 2025 оны төсвийн нийт зарлагыг 2,3 их наяд төгрөгөөр бууруулан дахин боловсруулж, улмаар 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 2025-2027 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг алдагдалгүй байхаар дунд хугацааны төсвийн хүрээг баталсан.

Мөн Монгол Улсын Их Хурал 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 52, 54 дүгээр тогтоолуудыг баталж, төсвийн зарлагыг нэмэгдүүлж буй хууль тогтоомжийг судлан цэгцлэх, татаас, урамшууллын үр нөлөөг үнэлэх, төсөвт байгууллагын чиг үүргийн давхардлыг арилгах, бүтэц, орон тоог оновчтой болгох, Засгийн газрын тусгай сан, гадаад зээл, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өр, авлагад үнэлгээ хийх зэргийг хэрэгжүүлэхээр Засгийн газарт хугацаатай үүрэг чиглэл болгосон.

2026 онд экспортын орлого нэмэгдэж, гадаад худалдааны тэнцэл ашигтай гарснаар гадаад орчны нөхцөл харьцангуй таатай байна. Гэвч энэ боломжийг төсвийн зарлага, алдагдлыг бууруулахад ашиглахын оронд улам нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлж байна.

Тухайлбал, 2026 оны 5 дугаар сард баталсан төсвийн хүрээгээр 2027 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 34,780 их наяд төгрөг, нийт зарлагын дээд хэмжээг 36,493 их наяд төгрөг, төсвийн алдагдлыг 1,713 их наяд төгрөг байхаар баталсан бол Засгийн газраас 2026 оны 8 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төсвийн төсөлд орлогыг 41,3 их наяд төгрөг, нийт зарлагыг 43,6 их наяд төгрөг, алдагдлыг 2,306 их наяд төгрөг байхаар тусгасан байна.

2026000155

Ингэснээр 2026 оны 5 дугаар сард батлсан төсвийн хүрээтэй харьцуулахад 2027 оны тэнцвэржүүлсэн орлого ойролцоогоор 6,5 их наяд төгрөгөөр нэмэгдэж байгаа боловч нийт зарлагын дээд хэмжээ 7,1 их наяд орчим төгрөгөөр өсөж, төсвийн алдагдал дахин нэмэгдэхээр байна.

Үүний зэрэгцээ Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, тодорхой нэмэлт орлого, эх үүсвэрийн хэмжээгээр төсвийн зарлагын дээд хэмжээг нэмэгдүүлэх, 2027 онд төсвийн зарлагын өсөлтийн зарим тусгай шаардлагыг өөрчлөх саналыг төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлээд байна.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан эдийн засгийн гадаад орчин харьцангуй таатай байгаа үед төсвийн зарлага, алдагдлыг нэмэгдүүлэх болсон үндэслэл, 2024 онд баримталсан мөчлөг сөрсөн, алдагдалгүй төсвийн бодлогын залгамж чанар, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын 52, 54 дүгээр тогтоолын хэрэгжилтийн бодит үр дүнг тодруулах шаардлагатай гэж үзсэн.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасны дагуу дараах асуулгыг тавьж байна.

Нэг.Мөчлөг сөрсөн, алдагдалгүй төсвийн бодлогын хэрэгжилтийн талаар

2024 онд эдийн засгийн таатай үед төсвийн зарлагын өсөлтийг хязгаарлах, төсвийн алдагдал болон өрийг бууруулах, хуримтлалыг нэмэгдүүлэх замаар мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлэх, 2025-2027 оны төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг алдагдалгүй байлгах бодлого чиглэлийг баримталсан. Үүнтэй холбогдуулан:

1.1.Дээрх бодлогын зарчим өнөөдөр хүчин төгөлдөр хэвээр байгаа эсэх талаарх Засгийн газрын байр суурь;

1.2.Экспортын орлого болон гадаад худалдааны ашиг нэмэгдэж, гадаад секторын нөхцөл харьцангуй таатай байгаа үед төсвийн зарлага, алдагдлыг нэмэгдүүлж байгаа нь мөчлөг сөрсөн төсвийн бодлогын зарчимтай нийцэж байгаа эсэх талаарх макро эдийн засгийн тооцоо, судалгаа, дүгнэлт;

1.3.Бодлогын чиглэлийг өөрчилсөн бол уг өөрчлөлтийн эдийн засгийн үндэслэл, холбогдох шийдвэр, төсвийн бодлогын шинэ зорилт;

1.4.Экспортын гол бүтээгдэхүүний үнэ, биет хэмжээ буурах, гадаад орчин муудах үед эдийн засгийг дэмжих төсвийн бодлогын орон зайг бүрдүүлэх дунд хугацааны төлөвлөлт;

1.5.2024 оны 12 дугаар сараас хойш 2027 оны төсвийн тэнцлийн зорилтод оруулсан өөрчлөлт бүрээр тэнцвэржүүлсэн орлого, урсгал болон хөрөнгийн зардал, суурь тэнцэл, төсвийн алдагдал, Засгийн газрын өрийн үзүүлэлтийн харьцуулалт.

Хоёр.2027 оны төсвийн орлого, зарлага, алдагдлын өөрчлөлтийн талаар

2026 оны 5 дугаар сард батлсан төсвийн хүрээтэй харьцуулахад 2026 оны 8 дугаар сарын 31-ний өдөр өргөн мэдүүлсэн өөрчлөлтийн төслөөр 2027 оны

2026000155

тэнцвэржүүлсэн орлого ойролцоогоор 6,5 их наяд төгрөгөөр нэмэгдэж байгаа боловч нийт зарлагын дээд хэмжээ 7,1 их наяд орчим төгрөгөөр өсөж, төсвийн алдагдал 1,713 их наяд төгрөгөөс 2,306 их наяд төгрөг болж нэмэгдэхээр байна. Үүнтэй холбогдуулан:

2.1.Орлогын нэмэгдлийн эх үүсвэр тус бүр, мөнгөн дүн, нэг удаагийн болон жил бүр давтагдах шинж;

2.2.Нийт зарлагын өсөлтийн эдийн засгийн ангилал, гол хөтөлбөр, арга хэмжээний задаргаа;

2.3.Нэмэгдсэн зарлагын нэг удаагийн хөрөнгө оруулалт болон жил бүр давтагдах урсгал зардлын харьцаа;

2.4.Цалин, тэтгэвэр, тэтгэмж, татаас, шилжүүлэг, бараа үйлчилгээний болон бусад урсгал зардлын өсөлтийн хэмжээ;

2.5.Орлого нэмэгдсэн хэмжээгээр төсвийн алдагдал, Засгийн газрын өрийг бууруулах, төсвийн хуримтлалыг нэмэгдүүлэх хувилбарын тооцоо болон харьцуулсан үр дүн;

2.6.Орлогын өсөлтийн экспорт, уул уурхайн салбарын мөчлөгөөс шууд болон шууд бусаар хамаарах хэсгийн хэмжээ;

2.7.Экспортын болон уул уурхайн орлого буурах нөхцөлд 2027–2029 оны төсөвт үүсэх эрсдэлийн үнэлгээ.

Гурав. Байгын зардлын дунд хугацааны санхүүжилт

2026 оны төсвийн тодотголоор төрийн албан хаагчдын цалин, тэтгэвэр, татаас болон бусад чиглэлээр шинээр бий болгосон буюу нэмэгдүүлсэн байгын шинжтэй зардал тус бүрээр:

3.1.2026 онд шаардагдах санхүүжилтийн хэмжээ;

3.2.2027 оны бүтэн жилийн санхүүжилтийн хэрэгцээ;

3.3.2027 оны төсвийн төсөлд тусгасан хэмжээ;

3.4.Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл болон бусад дагалдах зардлыг оролцуулсан нийт төсвийн өртөг;

3.5.Улсын төсөв, орон нутгийн төсөв, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан болон бусад холбогдох төсөв, санд үзүүлэх нөлөөлөл;

3.6.Тухайн байгын зардлыг санхүүжүүлэхээр тооцсон байгын орлогын эх үүсвэр;

3.7.Дээрх үзүүлэлтийн 2026–2029 оны дунд хугацааны тооцоо.

Мөн Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2026 оны төсвийн тодотголд тусгасан төсвийн хэмнэлтийг дараах ангилалаар:

2026009155

3.8.Бүтэц, орон тоо, чиг үүргийн бодит өөрчлөлтөөс бий болсон жил бүр давтагдах бүтцийн хэмнэлт;

3.9.Худалдан авалт, бараа үйлчилгээний зардлыг тогтвортой бууруулснаар бий болсон хэмнэлт;

3.10.Тухайн төсвийн жилд хойшлуулсан, санхүүжүүлээгүй зардал;

3.11.Гүйцэтгэл гараагүй болон бусад шалтгаанаар бий болсон нэг удаагийн хэмнэлт;

3.12.Шинээр бий болгосон байнгын зардлын бүтэн жилийн зардлын тооцоо болон жил бүр давтагдах бүтцийн хэмнэлтийн харьцуулалт, дунд хугацааны санхүүжилтийн зөрүү.

Дөрөв. Төсвийн тусгай шаардлагын хэрэгжилт

Засгийн газраас 2027 оны төсвийн төсөлтэй хамт Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, төрийн өмчит компаниудын нэмэлт ногдол ашиг, Оюутолгой төслийн ногдол ашиг, орон нутгийн үнэт цаас, урьд оны төсвийн үлдэгдэл болон бусад тодорхой эх үүсвэрийн хэмжээгээр нэгдсэн төсвийн зарлагын дээд хэмжээг нэмэгдүүлэх, 2027 онд төсвийн зарлагын өсөлтийн зарим тусгай шаардлагыг хамаарахгүй байхаар зохицуулалт санал болгосон байна.

Үүнтэй холбогдуулан:

4.1.Нэмэлт орлого, эх үүсвэр тус бүрийн хэмжээ, тогтвортой болон нэг удаагийн шинж;

4.2.Эдгээр орлого, эх үүсвэрээр байнгын шинжтэй урсгал зардал санхүүжүүлэхээр төлөвлөсөн эсэх;

4.3.Нэмэлт орлого бий болсон хэмжээгээр төсвийн зарлагын дээд хэмжээг нэмэгдүүлэх нь мөчлөг сөрсөн төсвийн бодлогын зарчимтай нийцэж байгаа эсэх талаарх тооцоо, дүгнэлт;

4.4.Тухайн орлогыг төсвийн алдагдал, Засгийн газрын өрийг бууруулах, төсвийн болон баялгийн сангийн хуримтлалыг нэмэгдүүлэхэд ашиглах хувилбарын тооцоо;

4.5.2027 онд төсвийн зарлагын өсөлтийн тусгай шаардлага хамаарахгүй байх эдийн засаг, төсвийн бодлогын үндэслэл;

4.6.Хүчин төгөлдөр төсвийн тусгай шаардлагыг өөрчлөхгүйгээр 2027 оны төсвийн төслийг боловсруулсан тохиолдолд нийт зарлагад шаардагдах бууралтын хэмжээ;

4.7.Төсвийн төсөл өргөн мэдүүлэхтэй зэрэгцүүлэн хүчин төгөлдөр төсвийн тусгай шаардлагад үл хамаарах буюу түүнийг сулруулах зохицуулалт санал болгож байгаа нь төсвийн сахилга, дунд хугацааны тогтвортой байдал, төсвийн дүрмийн итгэлцэлд үзүүлэх нөлөөллийн эрх зүй, төсвийн бодлогын үнэлгээ.

2026003155

Тав. Монгол Улсын Их Хурлын 52, 54 дүгээр тогтоолын хэрэгжилт

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 52, 54 дүгээр тогтоолоор Засгийн газарт төсвийн зардлыг шууд нэмэгдүүлдэг хууль тогтоомжийг судлах, бүх төрлийн татаас, урамшууллын үр нөлөөг үнэлэх, төсөвт байгууллагын чиг үүргийн давхардлыг арилгах, бүтэц, орон тоог оновчтой болгох, Засгийн газрын тусгай сангийн үр ашиг, зарцуулалтад үнэлгээ, аудит хийх, гадаад зээлийн төслүүдийг үр ашгаар эрэмбэлэх, хувийн хэвшлээр хэрэгжүүлэх боломжтой төслийг гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй байх, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өр, авлага, зээлд дүн шинжилгээ хийх зэрэг тодорхой үүргийг хугацаатай өгсөн.

Иймд дээр дурдсан Монгол Улсын Их Хурлын 2024 оны 52, 54 дүгээр тогтоолын заалт тус бүрийн хэрэгжилтийн талаар дараах мэдээлэл:

5.1.Хэрэгжүүлэхээр тогтоосон хугацаа;

5.2.Хариуцах байгууллага;

5.3.Өнөөгийн хэрэгжилтийн хувь болон үнэлгээний аргачлал;

5.4.Гарсан шийдвэр, хууль, журам;

5.5.Хийсэн судалгаа, аудит, үнэлгээ;

5.6.Монгол Улсын Их Хуралд тогтоосон хугацаанд танилцуулсан эсэх;

5.7.Төсвийн орлого, зарлагад үзүүлсэн хэмжигдэхүйц үр нөлөө;

5.8.Бодитоор бий болсон нэг удаагийн хэмнэлт;

5.9.Бодитоор бий болсон жил бүр давтагдах бүтцийн хэмнэлт.

Түүнчлэн:

5.10.Монгол Улсын Их Хурлын 2024 оны 52 дугаар тогтоолд заасан төсвийн зардлыг шууд нэмэгдүүлж, төсвийн тэнцэлд сөргөөр нөлөөлж байгаа хүчин төгөлдөр хууль тогтоомжийн судалгаа, түүнээс гарсан санал, хэрэгжилт;

5.11.Төсвөөс олгож байгаа бүх төрлийн татаас, урамшууллын үр нөлөөний судалгаа, төсвийн ачааллыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн;

5.12.Монгол Улсын Их Хурлын 2024 оны 54 дүгээр тогтоолд заасан төсөвт байгууллагын бүтэц, орон тооны оновчлолын үр дүн;

5.13.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн биелэлтэд хийсэн үнэлгээ, аудитын тайлан, бүтцийн өөрчлөлт болон төсвийн үр нөлөө;

5.14.Гадаад зээлийн төслүүдийн үр ашгийн эрэмбэ, удаашралтай болон үр ашиггүй төслүүдийн талаар авсан арга хэмжээ;

5.15.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өр, авлага, зээлд хийсэн дүн шинжилгээ, төсөвт учрах эрсдэлийг бууруулах арга хэмжээ;

2026000155

5.16.Дээрх арга хэмжээний үр дүнд бий болсон жил бүр давтагдах нийт бүтцийн хэмнэлт;

5.17.Уг бүтцийн хэмнэлт болон 2026 оны төсвийн тодотгол, 2027 оны төсвийн төслөөр шинээр бий болсон байнгын шинжтэй зардлын 2027–2029 оны өртгийн харьцуулалт.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлмэгц мөн зүйлийн 12.4 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх болно.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Ж.БАЯРМАА

2026009155